

МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/118

Зуунмод

Газар эзэмших эрхийг баталгаажуулж,
хаягийн зөрчил арилгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2, Монгол улсын засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төв аймгийн Зуунмод сумын нутаг дэвсгэрт байрлах Төв Чандмань ДЭХГ-ын Дулааны станцын зориулалтаар эзэмшиж буй газрын хаяг Нацагдорж 5-р баг, хурдан морины барианы газрын баруун урд гэснийг Номт 1-р баг, Үйлдвэрийн бүс, Наадамчдын гудамж 400 тоот болгон өөрчилж Төв Чандмань ДЭХГ/3855562/-т дээрх зориулалтаар 60 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч Төв Чандмань ДЭХГ/Ц.Жамбалсүрэн/-т дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.


2.2. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.3. Холбогдох хууль тогтоомж, хэсэгчилсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн А/472 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 000210